



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 15

Хажуу шинэ ус

Говь Угтаал сумын 2016 оны төсвийн
гүйцэтгэлийг батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.3 дахь заалт, Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн "Б" заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг 36 291 338,16 төг, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 2 502 500 төг, санхүүгийн дэмжлэгийг 202 145 000 төг, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилтийг 572 551 900 төг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтийг 145 968 900 төг, төсвийн зарлагыг 805 752 483 төг, орон нутгийн хөгжлийн сангийн зарлагыг 140 968 900 төгрөг, тусгай сангуудын зарлагыг 39 666 890 төгрөгөөр тус тус баталсугай.

2. Санхүүгийн сахилга батыг сайжруулж, төсвийг хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулж төсвийн тухай хууль, төрийн сангийн заавар журмыг мөрдөж ажиллахыг төсвийн шууд захирагчид, нягтлан бодогч нарт даалгасугай.

3. Төсөв зарцуулалтанд хяналт тавьж төсвийн тухай хууль, холбогдох заавар журмыг чанд мөрдөж ажиллахыг Төсвийн ерөнхийлан захирагч Б.Доржсүмбэр, Ерөнхий нягтлан бодогч Э.Уранбилэг нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ЦЭРЭНМӨНХ



040001



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 16

Хажуу шинэ ус

Говь-Угтаал сумын 2017 оны төсвийн
тодотгол батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2 дахь заалт, Засаг, захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ийн "Б" заалт, Дундговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 сарын 25-ний өдрийн 15 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

Нэг. Сумын 2017 оны төсөвт төвлөрүүлэх орлогын нэр төрөл, хэмжээг дор дурдсанаар баталсугай:

д/д	Байгууллага, орлогын нэр төрөл	ДҮН /мянган төгрөг/
1.1	Сумын төсвийн татварын орлого	22750,7
1.1.1	Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1.1-д заасан орлогод ногдох албан татвараас бусад хувь хүний орлогын албан татвар	11260,7
1.1.2	Бууны албан татвар	1940,0
1.1.3	Улсын тэмдэгтийн хураамж	2174,0
1.1.4	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	5790,4
1.1.5	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	1585,6
1.2	Сумын төсвийн татварын бус орлого	12000,0
1.2.1	Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг	
1.2.2	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг ашигласны төлбөр болон борлуулсны орлого, хүү, торгуулийн орлого	6000,0
1.2.3	Хууль тогтоомжийн дагуу сумын төсөвт орох бусад орлого	6000,0
	НИЙТ ДҮН	34750,7

Хоёр. Сумын 2017 оны төсөвт төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа байгууллага, бусад байгууллагын төвлөрүүлэх орлогын хэмжээг хавсралтаар баталсугай:

д/д	ТЭЗ, түүний харьяа байгууллага	ДҮН /мянган төгрөг/
2.1.	Засаг даргын тамгын газар	1000,0

040003

2.2	Соёлын төв	2000.0
2.3	Ерөнхий боловсролын сургууль	150.0
	НИЙТ ДҮН	3150.0

Гурав. Сумын 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

д/д	Төсвийн захирагч	ДҮН /мянган төгрөг/
3.1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	67548,1
3.2	Засаг даргын тамгын газар	168004,5
3.3	Багийн засаг дарга	29510,0
	НИЙТ ДҮН	265062,6

Дөрөв. Сумын төсвөөс 2017 оны төсвийн жилд зарцуулах зарлагын хэмжээг 1158492,6 мянган төгрөгөөр баталсугай.

Тав. Сумын төсвийн хөрөнгөөр 2017 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт (барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж)-ын зардлын хэмжээг 62920,0 мянган төгрөгөөр баталсугай.

Зургаа. Сумын төсвөөс аймаг (нийслэл)-ийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 129102,6 мянган төгрөгөөр баталсугай.

Долоо. Сумын төсвөөс 2017 оны төсвийн жилд төсвийн шууд захирагчдад олгох Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээг дор дурдсанаар баталсугай.

д/д	Төсвийн захирагч	ДҮН /мянган төгрөг/
7.1	Ерөнхий боловсролын сургууль	352703,6
7.2	Хүүхдийн цэцэрлэг	161058,2
7.3	Соёлын төв	53046,9
	НИЙТ ДҮН	566808,7

Найм. Сумын 2017 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэрийг дор дурдсанаар баталсугай:

1. Сумын татварын болон татварын бус орлого 34750,7 мянган төгрөг;
2. Сумын төсөвт Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг 229311,9 мянган төгрөг;
3. Сумын төсвийн урьд оны үлдэгдэл 17459,6 мянган төгрөг;
4. Сумын төсөвт аймаг (нийслэл)-ийн төсвөөс шилжүүлэх тусгай зориулалтын шилжүүлэг 564658,7 мянган төгрөг.

Ес. Сумын 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл сангуудад дор дурдсан орлогыг төвлөрүүлэх эрх олгосугай

д/д	Төсвийн захирагч	ДҮН /мянган төгрөг/
9.1	Байгаль хамгаалах сан	35000,0
9.2	Сум хөгжүүлэх сан	100000,0
9.3	Мал хамгаалах сан	20000.0

НИЙТ ДҮН	155000,0
-----------------	-----------------

Сумын 2017 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч төсөл сангуудад дор дурдсан төсөв зарцуулах эрх олгосугай:

д/д	Төсвийн захирагч	ДҮН /мянган төгрөг/
9.1	Байгаль хамгаалах сан	45800,0
	Оны эхний үлдэгдлээс	11906,6
	Туслах үйл ажиллагааны орлого	33893,4
9.2	Сум хөгжүүлэх сан	190000,0
	Оны эхний үлдэгдлээс	96038,3
	Туслах үйл ажиллагааны орлого	93961,7
9.3	Мал хамгаалах сан	21510,0
	Оны эхний үлдэгдлээс	2339,2
	Туслах үйл ажиллагааны орлого	19170,8
9.4	ИТХ-ын ахмадын сан	1209,0
	Оны эхний үлдэгдлээс	1209,0
9.5	ЗДТГ-ын ахмадын сан	3132,6
	Оны эхний үлдэгдлээс	3132,6
9.6	Дунд сургуулийн ахмадын сан	1623,9
	Оны эхний үлдэгдлээс	1623,9
9.7	Цэцэрлэгийн ахмадын сан	425,8
	Оны эхний үлдэгдлээс	425,8
9.8	Орон нутгийн хөгжлийн сан	62920,0
	Оны эхний үлдэгдлээс	11000,0
	Орон хөгжлийн сангийн санхүүжилтээс	51920,0
	НИЙТ ДҮН	326321,3

Арав. "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт"-ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Арван нэг. Сумын төсвийн хөрөнгөөр 2017 оны төсвийн жилд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Арван хоёр. Орон нутгийн хөгжлийн сангаар 2017 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

ДАРГА



Б.ЦЭРЭНМӨНХ

Сумын ИТХ-ын 2017 оны 05 сарын 17
 өдрийн 3 дугаар хуралдааны 16
 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоо болон хэмжээний үзүүлэлт

д/д	ТЕЗ, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт	2017 оны зорилтот түвшин
1.	Сум иргэдийн төлөөлөгчдийн Хурлын дарга	67548,1
1.1	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа	
1.1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	67548,1
2.	Сумын засаг дарга	
2.1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	168004,5
2.1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	164684,5
2.1.2	Орон нутгийн нөөц хөрөнгө	2970,0
2.1.3	Биеийн тамир уралдаан тэмцээн	350,0
2.2	Багийн хөгжлийг дэмжих	29510,0
2.2.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	29510,0
2.3	Ерөнхий боловсрол	352703,6
2.3.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	319639,6
2.3.2	Үдийн цай	11220,0
2.3.3	Дотуур байрны үйлчилгээ	21844,0
2.4	Сургуулийн өмнөх боловсрол	161058,2
2.4.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	133658,3
2.4.2	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	27399,9
2.5	Соёл урлаг	53046,9
2.5.1	Үндсэн үйл ажиллагааны зардал	51046,9
2.5.2	Уран бүтээлийн зардал	2000,0

Сумын ИТХ-ын 2017 оны 15 сарын 14
 өдрийн 3 дугаар хуралдааны 16
 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



Сумын төсвийн хөрөнгөөр 2017 оны төсвийн жилд
 хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ,
 барилга байгууламжийн жагсаалт

(мянган төгрөг)

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Нийт төсөвт өртөг	2017 онд санхүүжүүлэх дүн
НИЙТ ДҮН				62920,0	62920,0
Шилжих хөрөнгө оруулалт				29249,1	29249,1
1	Сумын ерөнхий төлөвлөгөө боловсруулах	2015	2017	20031,1	20031,1
2	Цахим аймаг	2016	2017	9218,0	9218,0
Шинэ хөрөнгө оруулалт					
Хөрөнгө оруулалт					
1					
2					
3					
Их засвар				12000,0	12000,0
1	Нийтийн эзэмшлийн байгууламжийн засвар тохижилт	2017	2017	7000,0	7000,0
2	Хогийн цэгийг хашаажуулах	2017	2017	5000,0	5000,0
3					
Тонг төхөөрөмж				4000,0	4000,0
1	Соёлын төвийн гэрэлтүүлэг	2017	2017	4000,0	4000,0
2					
Төсөл арга хэмжээ				17670,9	17670,9
1	Үндэсний их баяр наадмын зардал	2017	2017	5000,0	5000,0
2	Зураг төсвийн зардал	2017	2017	5670,9	5670,9
3	Малын үүлдэр угсааг сайжруулах	2017	2017	7000,0	7000,0



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 17

Хажуу шинэ ус

Төсөл сонгон шалгаруулах орон тооны бус
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 1 дүгээр зүйлийн 1.6, 3 дугаар зүйлийн 3.1.13.1.2.3.1.3, 3.3 дах заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ НЬ:

1. Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга:	Б.Доржсүмбэр	/Засаг дарга/
Нарийн бичгийн дарга:	Т.Цэрэнчунт	/ЖДҮХ ажилтан/
Гишүүдэд:	Э.Уранбилэг	/Ерөнхий нягтлан бодогч/
	С.Дугарбаатар	/1-р багийн төлөөлөл/
	Б.Соёлмаа	/2-р багийн төлөөлөл/
	Д.Амгалан	/3-р багийн төлөөлөл/
	Т.Энхжаргал	/Банкны төлөөлөл/

2. Суманд жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд баримтлах чиглэлийг хавсралтаар баталсугай.

3. Төсөл сонгон шалгаруулахад иргэдийн оролцоог хангах, гэрээний биелэлтийг хангуулах, хэрэгжилтийн явц, үр дүнд байнгын хяналт тавьж, сангийн үйл ажиллагааны үр дүнг сумын ИТХ-ын төлөөлөгчдийн хуралд хагас, бүтэн жилээр тайлагнахыг зөвлөлийн дарга /Б.Доржсүмбэр/-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭРЭНМӨНХ



040006

Сумын ИТХ-ын 2017 оны ...сарын ...
 өдрийн ...дугаар хуралдааны ...
 дугаар тогтоолын хавсралт



2017 онд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд баримтлах чиглэл

Д/д	Салбар		Чиглэл
1	Хөдөө аж ахуйн салбар	Малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэл	Сүү,сүүн бүтээгдэхүүн
			Мах махан бүтээгдэхүүн
			Арьс шир боловсруулах ба бүтээгдэхүүн үйлдвэрлэх
			Дайвар ба бусад түүхий эд
2	Газар тариалан	Хүнсний ногоо	Хүлэмжийн аж ахуй
			Хүнсний ногоо
3	Хөнгөн үйлдвэрлэл	Интернет кафе	Зурагчин,компьютерийн бүх төрлийн үйлчилгээ,хэвлэлийн эх бэлтгэх гэх мэт
		Гуталчин	Гутал зан засвар
		Үсчин гоо сайхан	Үсчин гоо сайхан
4	Аялал жуулчлал		Амралтын газар, жуулчны бааз



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 18

Хажуу шинэ ус

Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ НЬ :

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Цэрэнмөнх /ИТХ-ын дарга/

Гишүүдэд: Х.Баясгалан /төрийн сангийн мэргэжилтэн/

Д.Дагмидмаа /Иргэдийн төлөөлөл/

Д.Алтансаргай /Иргэдийн төлөөлөл/

Б.Воля /Иргэдийн төлөөлөл/

2. Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж байгаа болон гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавьж, сангийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дүн, гүйцэтгэлийн тайланг сумын ИТХ-ын Төлөөлөгчдийн Хуралд хагас, бүтэн жилээр тайлагнахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Цэрэнмөнх/-д даалгасугай.

ДАРГА  Б.ЦЭРЭНМӨНХ



040008



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 19

Хажуу шинэ ус

“Цэвэр сум” аяны удирдамж
батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дах заалт, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ НЬ :

1. Хог хаягдлын менежментийг иргэдийн оролцоотой сайжруулах “Цэвэр сум” аяны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. Аяны удирдамжийг сурталчлан таниулах, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллан зохион байгуулсан ажлын тайлан мэдээлэлийг 12 дугаар сард ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд тайлагнахыг сумын Засаг дарга /Б.Доржсүмбэр/-г үүрэг болгосугай.

ДАРГА  Б.ЦЭРЭНМӨНХ



040010

Сумын ИТХ-ын 2017 оны 4 сарын 19
өдрийн 3 дугаар хуралдааны 19
дүгээр тогтоолын хавсралт

Говь-Угтаал сумын "Цэвэр сум" аяны удирдамж

Нийтлэг үндэслэл:

Сумын төв, хөдөөд орчны агаар, ус, хөрс их хэмжээгээр бохирдож байгаагийн дотор амьдралын нөхцлийг доройтуулж, орчныг бохирдуулж буй гол хүчин зүйл нь хог хаягдал юм. Иймээс иргэд хүлээсэн үүргийнхээ дагуу хог хаягдлыг зайлуулах, цэвэр орчин бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай болоод байна. Ахуйн гаралтай хог хаягдлын 60% нь цаас 25-30% нь төрөл бүрийн нийлэг материал, бусад нь төмөр, шил шаазан, хүнсний зүйлийн хаягдал байгаа бөгөөд бүтэц нь улирлын байдлаас хамаарч өөрчлөгдөн хүйтний улиралд хог хаягдлын ихэнх хувийг үнс эзэлдэг байна. Хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, хог хаягдлыг хүрээлэн буй орчноос зайлуулах, ялгах дахин ашиглах замаар түүний хэмжээг бууруулах үйл ажиллагаанд төр, иргэн, ААН, байгууллагууд хамтран идэвхи санаачлагатай оролцох шаардлага тулгараад байна. Иймээс "Цэвэр сум" аяныг зохион байгуулахаар төлөвлөж дараах удирдамжийг боловсруулан гаргалаа.

Зорилго: Иргэдийн эрүүл цэвэр, тохилог орчинд ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлэх, байгаль орчноо хамгаалах түүнийг бохирдлоос урьдчилан сэргийлэх сэтгэлгээг төлөвшүүлэхэд оршино.

Хэрэгжих хугацаа: 2017 оны 06 сарын 01 нээс 2017 он дуустал

Хамрах хүрээ: Говь-Угтаал сумын нийт нутаг дэвсгэр, айл өрх, албан байгууллага аж ахуй нэгж, тус суманд түр болон байнга оршин сууж буй бүх насны иргэд

Зохион байгуулагч: Засаг даргын Тамгын газар, эрүүл мэндийн төв, зохион байгуулах ажлын хэсэг

Шалгаруулах төрөл: Цэвэрч өрх, цэвэрч малчин өрх, хот айл, цэвэрч албан байгууллага, аж ахуй нэгж, цэвэрч баг, цэвэрч хороолол

Сумын төвийн хороолол: Баян далай, Хөрш, Нарлаг дэнж, Нарлаг,

- Баяндалай /Баяндалай, эрчим хорооллууд нэгдэнэ/
- Хөрш /Отгонбатынх ороод баруун тийш эмнэлэгийн 4айлын орон сууцнаас хойш/
- Нарлагдэнж /Шар орон сууцны эгнээ ороод түүнээс хойш/
- Нарлаг /Гандангийн урд эгнээнээс урагш Өлзийбүрэнгийнх ороод урагш бүх өрх/

Цэвэрч хороололын болзол:

- Гудамж нэг эгнээнд жигдэрсэн байх
- Хашааны өнгө үзэмжийг сайжруулсан байх
- Гудамж бүр хог хаягдалгүй, цэвэр байх
- Хороолол бүр даргатай болж нэгдсэн зохион байгуулалтанд орсон байх
- Зохион байгуулалттай арга хэмжээнд бүрэн хамрагдсан байх

Цэвэрч айл өрхийн болзол:

- Хогийн савтай байж хогоо ил задгай асгадаггүй байх
- Стандартын шаардлага хангахуйц бие засах газар, 00-той байж ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн байх
- Тусдаа бохирын цооногтой байх
- Хог хаягдлын хураамжаа тогтмол төлж хэвшсэн байх
- Хашааны гадна дотно орчныг тогтмол цэвэрлэж хэвшсэн байх
- Хашаандаа гэрэлтүүлэгтэй байх
- Гэрийн тэжээвэр амьтан нохой муурыг уяж туулгалтанд хамруулсан байх

Цэвэрч албан байгууллага, ААН-ийг шалгаруулах болзол /ААН, Албан байгууллагууд, Хараат, Хамтын хүч/

- Автомашины зогсоолтой, зогсоолын тэмдэгтэй байх
- Гадна гэрэлтүүлэгтэй байх
- Өөрийн эзэмшлийн талбай буюу хашаанаас гадна 50м зайд, батлагдсан хуваарийн дагуу цэвэрлэгээг тогтмол хийж, хог хаягдалгүй байх
- Бие засах газрын асуудлыг шийдвэрлэсэн, цэвэр байх
- Үйлчилгээний газар бүр тэргэнцэрийн замтай болсон байх
- Байгууллага, ААН бүр хог хаягдлын цэгтэй байх
- Үйлчилгээний газар бүр хогийн савтай байх
- Хоол хүнс бүхий албан байгууллага аж ахуй нэгж нь үйлчилгээний газрын стандарт, эрүүл ахуйн шаардлагыг хангасан байх
- Гадна орчны өнгө үзэмжийг сайжруулж цэцэрлэгжүүлэлт хийгдсэн байх, тухай бүрд нь баримтжуулсан байх

Цэвэрч малчин өрх, хот айл шалгаруулах болзол:

- Малын хашаа хорооны орчин цэвэр байх /хорооноос эргэн тойрон 150м/
- Хороо бууцыг сийлж, өтөг бууцыг нэг цэгт төвлөрүүлж цэвэрлэсэн байх
- Хашаа хороог засаж сэлбэж, тохижуулсан байх
- Өвөлжөө хаваржаандаа бие засах газар буюу 00-той байж ариутгасан байх
- Намаржаа зунжааныхаа нутаг /буйр/-ыг цэвэрлэж хэвших
- Шатааж устгах боломжгүй /шил, шаазан, төмөр, хуванцар сав г.м/ хогийг хогийн нэгдсэн цэгт төвлөрүүлэх
- Үхсэн малын сэг зэмийг устгах, ариутгах,
- Ус худгийн эзэмшил ашиглалтыг сайжруулж орчныг цэвэрлэх
- Гэрийн тэжээвэр амьтан нохой муурыг уяж туулгалтанд хамруулсан байх

Цэвэрч баг шалгаруулах болзол:

- Нийт малчин өрхийн 80-иас доошгүй хувь нь соёлч өрхийн болзол хангасан байх
- Багийн нутаг дэвсгэр дээрх бусдын хаясан хог хаягдал болон сэг, зэмийг цэвэрлэж хогийн цэгт авчирч байгаль орчноо цэвэрлэхэд санаачлага гаргасан байх /баримтжуулсан байх /
- Багийн нутаг дэвсгэр нь хог хаягдалгүй болсон байх

Уралдааны болзлыг жил бүрийн 12 дугаар сарын 20-ны дотор дүгнэж шагналыг 12 сарын 31 ний өдөр төв шинэ жилийн арга хэмжээн дээр гардуулна.

Шалгаруулах журам: Баг хороодын дарга, албан байгууллага аж ахуй нэгжийн дарга эрхлэгч нар уралдааны болзолыг хангахад санаачлага гарган, тогтмол хяналт тавьж, ажлын хэсэгтэй хамтарч ажиллах бөгөөд жилийн эцсийн хүн ам, малын тооллогоор дүгнэж шалгаруулна.

Шагнал: Цэвэрч өрх, цэвэрч малчин өрх, хот айл тус бүр 3-ыг шалгаруулж өргөмжлөл мөнгөн шагналаар, цэвэрч хороолол, баг, аж ахуй нэгж албан байгууллага тус бүр нэгийг тус тус шалгаруулж өргөмжлөлөөр шагнана.



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 80

Хажуу шинэ ус

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 18.1.2-ийн "з", Ашигт малтмалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 6, 5 дугаар зүйлийн 5.1, Дундговь аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ НЬ :

1. Сумын нутаг дэвсгэрт байгалийн өнгөт болон үнэт чулууг хууль бус аргаар олборлоход хяналт тавих, иргэдээс мэдээ мэдээлэл хүлээн авах журмыг хавсралтаар баталсугай.
2. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллан хэрэгжилтийг хуралдаанд танилцуулж ажиллахыг сумын Засаг дарга /Б.Доржсүмбэр/-т даалгасугай.
3. Байгаль орчныг хамгаалах сайн дурын иргэдийн нөхөрлөл байгуулж ажиллахыг багийн засаг дарга, багийн ИНХ-ын дарга нарт даалгасугай.

ДАРГА  Б.ЦЭРЭНМӨНХ



040012

Сумын ИТХ-ын 2017 оны 10 сарын 17
өдрийн 3 дугаар хуралдааны 3.0
дугаар тогтоолын хавсралт

**БАЙГАЛИЙН ӨНГӨТ БОЛОН ҮНЭТ ЧУЛУУГ ХУУЛЬ БУС АРГААР ОЛБОРЛОХОД
ХЯНАЛТ ТАВИХ, ИРГЭДЭЭС МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл.

Тус сумын нутаг дэвсгэр дээрх байгалийн өнгөт болон үнэт чулууг хууль бус аргаар олборлон зах зээлд худалдан борлуулж байгаль орчны унаган төрхийг алдагдуулж газрын хөрсийг эвдэж байгаа нь бэлчээрийг доройтуулж ургамалыг устаж үгүй болох, цаашид мал аж ахуйн эрхлэх боломжгүй болох нөхцлийг бүрдүүлж байна. Угтаал нутгийнхаа унаган байгалийг хамгаалах өвөг дээдсээс өвлөгдөн ирсэн эх нутгаа үр хүүхэд хойч үедээ онгон байдлаар нь үлдээх нь энэ нутагт амьдарч байгаа иргэн нэг бүрийн үүрэг болоод байна. Иймд өнгөт болон үнэт чулууг хууль бус аргаар олборлох үйл ажиллагаанд хяналт тавих, уг оролдлогыг таслан зогсооход иргэн бүрийн оролцоог хангах зорилгоор энэхүү журмыг боловсруулан сумын ИТХ-аар батлуулахаар оруулж байна.

Хоёр. Хяналт тавих чиглэл

- 2.1. Байгалийн өнгөт чулууг хамгаалах малчдын нөхөрлөл байгуулах
- 2.2. Байнгын болон тодорхой хугацааны эргүүл ажиллуулах
- 2.3. Үнэн зөв бодит мэдээллийг өгөх, хүлээн авах, мэдээллийн нууцыг хадгалах, урамшуулах
- 2.4. Хууль хяналтын байгууллагын ажилтануудыг ажил үүргийн дагуу татан оролцуулах
- 2.5. Ойр зэргэлдээх сумдын удирдлага, ажил хариуцсан албан тушаалтан, иргэдтэй хамтран ажиллах мэдээлэл солилцох
- 2.6. Байгалийн өнгөт чулууны тогтоц, талбайн хэмжээг нарийвчлан тогтоож, орон нутгийн тусгай хамгаалалтанд авах
- 2.7. Байгалийн өнгөт чулууг олборлосон этгээдийн талаархи мэдээллийг орон нутгийн мэдээллийн хэрэгслэлээр сонин, веб сайт, FM радиогоор түгээх
- 2.8. Төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

Гурав. Хууль бусаар олборлосон чулууг хэрхэн шийдвэрлэх тухай

- 3.1. Хураагдсан байгалийн өнгөт болон үнэт чулууг сумын өмч хамгаалах байнгын зөвлөлд жигнэн хүлээлгэн өгнө
- 3.2. Зөвлөлийн гишүүд чулууг битүүмжлэн хаяг, огноо, жинг тэмдэглэн, 2 хувь тэмдэглэл үйлдэн ЗДТГ-ын няравт хүлээлгэн өгч хадгалуулна

Дөрөв. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

- 4.1. Ашигт малтмалын тухай хуулийн 66.1.1 дэхь заалтын дагуу тусгай зөвшөөрөлгүй иргэн олборлолт хийсэн тохиолдолд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 30-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээний торгууль ногдуулна /7200000-12000000 төгрөг/



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 21

Хажуу шинэ ус

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "ж" дэх заалт, 24 дүгээр зүйлийг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын болон Тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал боловсруулан хэлэлцүүлэх журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг мөрдөж ажиллахыг сумын иргэдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгч, Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭРЭНМӨНХ

040014

Сумын ИТХ-ын 2017 оны 14 сарын 21
өдрийн 3 дугаар хуралдааны
дүгээр тогтоолын хавсралт

ГОВЬУГТААЛ СУМЫН ИТХ-ЫН БОЛОН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНД
АСУУДАЛ БОЛОВСРУУЛЖ ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Зорилго

Энэхүү журмын зорилго нь сумын ИТХ болон Тэргүүлэгчдийн хуралдаанаас гарах шийдвэрийг боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хэлэлцэж буй асуудалд иж бүрэн хандах, гарах шийдвэр оновчтой зөв байх, уг асуудлыг хуралдаанд оруулах, бэлтгэл хангах, хэлэлцэх, боловсруулах, шийдвэр гаргах түвшинд оролцогч этгээдүүдийн хүлээх үүргийг тодорхойлох харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хэлэлцэх асуудал

2.1. Хэлэлцэх асуудал нь ил тод нээлттэй, олон нийтийн оролцоог хангасан, ашиг сонирхлын зөрчлөөс ангид судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх нийтлэг зарчимтай байна.

2.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг төлөвлөгдсөн ба тулгамдсан гэж ангилна.

2.2. Төлөвлөгдсөн асуудал гэдэгт сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн жил, улирлын ажлын төлөвлөгөө, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, үндсэн чиглэл, бодлого хөтөлбөрүүдэд тусгагдсан болон хууль тогтоомжоор заавал хэлэлцэхээр хуульчлагдсан асуудлууд багтана.

2.3. Хуульд заасан эрх бүхий этгээдийн санал болгосон, санаачилсан, иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн мэдээлэл, өргөдөл гомдлын дагуу хуралдаанаар зайлшгүй нэн түрүүнд хэлэлцэх асуудлыг тулгамдсан асуудал гэж үзнэ.

2.4. Төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах шагналын тодорхойлолт, журмын дагуу бүрдүүлсэн материалыг сумын засаг дарга хүлээн авч сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлэн гарсан тогтоол, тэмдэглэл, зөвшөөрсөн саналын хамт аймгийн Засаг даргад албан бичгээр уламжлан хүргүүлнэ.

2.5. Улсын сайн малчин, эхийн алдар одон, ойн медаль, салбарын шагналууд, зааврыг үндэслэн материал нь бүрдэл болсон үед хурлын даргад танилцуулж Тэргүүлэгчдийн хуралд оруулна.

2.6. Орон нутгийн өмчийн тухай асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс гаргасан холбогдох журмын дагуу тухайн байгууллагын өмч хамгаалах зөвлөл дүгнэлт гаргаж сумын өмч хамгаалах байнгын зөвлөлд ирүүлнэ. Сумын өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлтээ гарган суманд шийдвэрлэх өмчийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ. Аймагт шийдвэрлүүлэх өмчийг сумын өмч хамгаалах зөвлөлийн санал дүгнэлтийг хавсарган Засаг даргын зөвшөөрсөн албан бичгээр орон нутгийн өмчийн албанд хүргүүлнэ.

Гурав. Хэлэлцэх асуудлыг тогтоох, бэлтгэл хангах

3.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хуралдаан болохоос 15-аас доошгүй хоногийн өмнө Тэргүүлэгчдийн хурлаас хуралдаан хийх газар, хугацааг товлож, хэлэлцэх асуудлын талаар тогтоол гаргаж, төлөөлөгчид, асуудал оруулагчид мэдээлнэ.

3.2. Хуралдаанд асуудал оруулж байгаа этгээд шаардлагатай тооцоо судалгаа, мэдээ, баримтыг холбогдох хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргуулах эрхтэй.

3.3. Хуралдаанд оруулах үндсэн мэдээлэл нь илтгэл, сонголт, мэдээлэл танилцуулгын хэлбэртэй, холбогдох тооцоо судалгаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргасан байна.

3.4. Асуудал оруулж буй этгээд хуралдаан болохоос 3 хоногийн өмнө цахим болон цаасан хэлбэрээр Ажлын албанд хүлээлгэн өгнө.

3.6. Ажлын алба хуралдаанаар хэлэлцэх асуудлын материалыг шалган хүлээн авч Хурлын даргад танилцуулан Төлөөлөгч, Тэргүүлэгчдэд хуралдаан болохоос 2 хоногийн өмнө бүх Төлөөлөгч, Тэргүүлэгчдэд цахим хаягаар болон цаасан хэлбэрээр хүргэнэ.

3.7. Төлөвлөгдөөгүй болон зарлагдаагүй асуудлыг хэлэлцэхдээ тухайн асуудлыг санаачилсан, санал болгосон эрх бүхий этгээд холбогдох хууль болон энэ журамд зааснаар материалаа өөрөө бэлтгэн хуралдаан болохоос 2 хоногийн өмнө тарааж хэлэлцүүлнэ.

Хуралдаанд асуудал оруулах хугацаа:

➤ Хуралдаанд оруулах үндсэн мэдээлэл нь илтгэл, сонсгол, мэдээлэл танилцуулгын хэлбэртэй, холбогдох тооцоо судалгаа, гарах шийдвэрийн төслийг хавсаргасан байх бөгөөд хугацаа нь 25 минутаас илүүгүй

➤ Хуралдааны тогтоол, бусад шийдвэрийн биелэлттэй холбоотой асуудлаар байгууллага, албан тушаалтнаас бэлтгэж хуралдаанд танилцуулж байгаа мэдээлэл нь 15 минутаас илүүгүй

➤ Нэг буюу хэд хэдэн төлөөлөгчид хамтарч эсвэл хороо, түр хороо, ажлын хэсэг, намын бүлгээс хууль тогтоомж, хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдсон асуудлаар Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтны бодлого, байр суурийг тодруулах, үр дүнг сонсох, тодорхой үйл ажиллагаа явуулахыг шаардаж бичгээр хандсан асуулгын хариуг 10 минутаас илүүгүй,

➤ Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар мэдээлэл авах, тодруулга хийх зорилгоор асуудал оруулагч, хурлын шийдвэр хариуцагч нарт хандаж төлөөлөгчдөөс амаар болон бичгээр тавьсан асуулгын хариуг 5 минутаас илүүгүй хугацаанд багтааж танилцуулахаар бэлтгэнэ.

➤ Эрх бүхий этгээдээс Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлаархи саналаа хуралдаан болохоос 5-аас доошгүй хоногийн өмнө албан бичгээр ирүүлнэ.

Хуралдааны бэлтгэл хангах

2.1. Хуралдааны зардлыг тооцон, бэлтгэл хангах төлөвлөгөө, хөтөлбөр, ажил үүргийн хуваарийг Хурлын дарга батласнаар ИТХ-ын ажлын алба, сумын ЗДТГ, асуудал оруулагчид биелэлтийг хангана. Зардалд хуралдаан явуулах, хороодыг ажиллуулах, бичиг хэрэг, гарын авлага, тараах материал бэлтгэх, төлөөлөгчдийн хоол, цай, техник хэрэгсэл, тээвэр унааны үйлчилгээ болон бусад зардлууд багтана.

2.2 Хуралдаанаар хэлэлцэх асуудлаар төрийн бус байгууллага, Хурлын хороод асуудлыг судлах, санал дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл бэлтгэх зорилгоор урьдчилан ажиллана.

2.3 Асуудал оруулагчид хуралдаанаар хэлэлцэх асуудлын төслийг телевиз, сонин, вэб сайт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилж, иргэний танхимаар дамжуулан ярилцлага, олон нийтийн хэлэлцүүлэг явуулан иргэд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудын санал, дүгнэлтийг авч илтгэл, мэдээлэлдээ тусгах арга хэмжээ авна.

2.4. Сумын дунд, урт хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө, сумын засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилт зэрэг эдийн засаг, нийгэм соёлын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн төслийг Засаг даргын зөвлөл, холбогдох байгууллагын хурлаар хэлэлцүүлж, Тэргүүлэгчдэд ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө урьдчилан хүргүүлж, тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн Тэргүүлэгчдийн хурлаас гаргасан санал, зөвлөмжийг тусган эцэслэн боловсруулж хуралдаанд танилцуулна.

2.5 Хэлэлцэх асуудлыг бэлтгэх, санал дүгнэлт гаргах, гарах шийдвэрийн төсөл боловсруулах зорилгоор тухайн асуудлыг эрхлэх Хурлын хороод асуудал оруулагчидтай нэгдсэн болон хэсэгчилсэн ярилцлагыг хуралдаан болохоос өмнө, шаардлагатай бол хуралдааны үеэр

хийнэ. Хурлын хороод, түр хороо болон ажлын хэсэг төлөөлөгчдийн саналыг авч нэгтгэн дангаараа болон хамтран санал дүгнэлт гаргаж болно.

2.6 Хурлын хороод, шаардлагатай тохиолдолд намын бүлгүүд нь санал дүгнэлтээ бичгээр үйлдэж, хуралдаан эхлэхээс нэг хоногийн өмнө Хурлын даргад танилцуулж хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

2.7 Асуулгын хариутай холбоотойгоор төлөөлөгчид нэмэлт тодруулга хийж, хариу авах шаардлагатай бол хуралдааны шийдвэрээр түр хороо, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

2.8 Хэлэлцэх асуудал нь боловсруулалтын шаардлага хангаагүй, өгсөн зөвлөмж чиглэлүүдийг тусгаагүй, сумын бодлого, иргэд, орон нутгийн нийтлэг эрх ашигт нийцээгүй гэж үзвэл урьдчилан Тэргүүлэгчдийн хурлаас, түүнчлэн хуралдаанд оролцогчдын олонхийн саналаар тодорхой хугацаатай үүрэг өгч буцааж болно.

2.9 Хуралдаанд холбогдох албан тушаалтнуудыг урилгаар оролцуулах, хуралдааны явцыг нь орон нутгийн телевиз, FM-ээр шууд болон хэсэгчлэн дамжуулах, улс төрийн болон ТББ-ууд, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудад ажиглах, сурвалжлах нөхцөл бүрдүүлж ил тод нээлттэй байдлыг хангана.

Дөрөв. Хуралд асуудал санаачлан өргөн мэдүүлэх, танилцуулах

4.1. Хурлын Тэргүүлэгч, Хороо, Төлөөлөгч, сумын Засаг дарга асуудал санаачлан хуралд хэлэлцүүлэхээр өргөн барих эрхтэй.

4.2. Багийн ИНХ, Төрийн болон Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэн асуудал хэлэлцүүлэх санал дэвшүүлж болно эсвэл саналаа төлөөлөгч, эрх бүхий этгээдээр дамжуулан өргөн бариулна.

4.3. Тэргүүлэгчид, Хороо, Төлөөлөгч, иргэнээс бусад эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж асуудал оруулах бол дарга нь хариуцан оруулна.

4.4. Засаг дарга түүний алба, төсөвт албан байгууллагаас асуудал оруулбал байгууллагын дарга, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн асуудлыг хуралд оруулж хэлэлцүүлэх бөгөөд хуралд Засаг дарга түүний эзгүйд орлогч дарга байлцана.

4.5. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж хуралдаанд тухайн ажлын уялдаа холбоо бүхий байгууллага, мэргэжилтэн, иргэдийн төлөөллийг байлцуулж болно.

4.6. Хуралдаанаар хэлэлцэж буй өмчийг сумын өмч хамгаалах байнгын зөвлөл, шаардлагатай бол аль нэг Тэргүүлэгч урьдчилан үзэж танилцсан байх бөгөөд тухайн өмчийг эзэмшигч байгууллагын дарга, ня-бо нарыг хуралдаанд оролцуулна.

4.7. Хуралдаанд асуудал оруулагч нь хэлэлцүүлж буй асуудлаар бодит дэлгэрэнгүй мэдээлэл өгөх үүднээс техник хэрэгсэл өргөн ашиглах үүрэг хүлээнэ.

Тав. Хүлээх хариуцлага

5.1. Энэхүү журмыг асуудал оруулж буй этгээд болон эрх бүхий байгууллага ажилтанд албан ёсоор гарын үсэг зуруулан танилцуулна.

5.2. Хуралдаанд асуудал оруулж буй этгээд нь энэ журмыг дагаж мөрдөх, хэрэгжүүлэх үүрэгтэй.

5.3. Энэхүү журмыг зөрчсөн, үл ойшоосон, хариуцлагагүй хандсан этгээд, албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгүүлэхээр холбогдох албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2017 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 22

Хажуу шинэ ус

Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.14 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын гуравдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн үйл ажиллагаандаа мөрдөх журмыг хавсралтаар баталсугай.
2. Журмыг мөрдөж ажиллахыг сумын иргэдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭРЭНМӨНХ

040018

- 2.6 Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тухайн жилийн ажлын төлөвлөгөөг батлаж хэрэгжүүлэх
- 2.7 Тодорхой асуудлаар судалгаа явуулж, боловсруулан дүгнэлт гаргаж сумын ИТХ-ын болон тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн барих
- 2.8 Монгол улсын хууль тогтоомж өөрийн гаргасан шийдвэрийн хэрэгжилт зэрэг асуудлаар хурлын хяналтыг хэрэгжүүлэх журмын хүрээнд ажиллана.

Гурав. Тэргүүлэгчдийн хуралдааны журам

- 3.1 Тэргүүлэгчдийн хуралдаан нь сумын ИТХ-ын дэг, сумын ИТХ-ын болон ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд асуудал боловсруулж, хэлэлцүүлэх журмыг мөрдөнө.
- 3.2 Сумын засаг дарга болон ЗДТГ-ын мэргэжилтнүүд, албан байгууллагын дарга эрхлэгчид хуралдаанд асуудал оруулахад хуралдаанд асуудал оруулах журмын дагуу оруулах
- 3.3 Баримт бичгийн төслийг тогтоосон журмын дагуу бүрдүүлж тараана.
- 3.3. Хурлын ажлын алба тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг хүлээн авч баримт бичгийн төслийг иж бүрдэл болгож, хуралдахаас өмнө хурлын даргад танилцуулж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгаж, ажлын 1–ээс доошгүй хоногийн өмнө материалыг хүргэсэн байна. Урьдчилан танилцуулах шаардлагагүй асуудлыг шууд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусган хуралдаанд оруулж болно.
- 3.4. Хуралдаанд хэлэлцэх баримт бичгийг ИТХ-ын Тэргүүлэгч бүрт цахим хаягаар болон цаасаар хувилж тараасан байна.
- 3.5. Хуралдааны зар, холбогдох баримт бичгийг тэргүүлэгч хүлээн авч тухайн хуралдаанд оролцох боломжгүй бол шалтгаанаа ажлын албанд урьдчилан мэдэгдсэн байна.
- 3.6. Хэлэлцэж байгаа асуудлын цар хүрээ, ач холбогдлоос хамаарч хуралдааныг өргөтгөсөн нээлттэй хэлбэрээр хийж болох бөгөөд үүнийг Хурлын дарга шийдвэрлэнэ.
- 3.7.Тэргүүлэгчид хуралдаанаар хэлэлцэх асуудлыг батална.
- 3.8. Хуралдааны төлөвлөгөөнд ороогүй боловч нэн яаралтай эсвэл зайлшгүй шаардлагатай хэлэлцэх асуудал гарвал хуралдаан даргалагчийн санал оруулснаар оролцсон тэргүүлэгчдийн олонхийн саналаар шийдвэрлэх
- 3.9.Тэргүүлэгчид ажлын дэвтэр дээрээ оролцсон хуралдаан бүрээрээ хуралдсан хугацаа, хэлэлцсэн асуудал, тавьсан асуулт, өгсөн хариу, гаргасан санал, шийдвэрлэсэн тухай болон бусад мэдээллийг бичиж үлдээнэ.
- 3.10. Хуралд оролцсон тэргүүлэгчид зөвшөөрсөн эсвэл татгалзсан тухай саналын аль нэгийг заавал өгөх үүрэг хүлээнэ.
- 3.11. Тэргүүлэгчдийн хуралдаан дээр тухайн асуудлаар холбогдох мэргэжилтний санал зөвлөгөөг сонсоно. Хурлын тэмдэглэлийг тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, түүний эзгүйд хурлын даргын томилсон аль нэг тэргүүлэгч хариуцан хөтөлнө.
- 3.12 Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсэн асуудал тус бүрээр нь бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд: Хурлаар хэлэлцсэн асуудлын төлөвлөгөө, хэлэлцэх асуудлын материал түүний хавсралт, судалгаа тооцоо, тэргүүлэгчдээс бичиж өгсөн санал, бусад байгууллага иргэдээс өгсөн санал зөвлөмж, тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхтэй холбоотойгоор ирүүлсэн, авсан бүх мэдээлэл, хурлын тэмдэглэл, гаргасан шийдвэрийн үндсэн хувь зэрэг байна.
- 3.13.Тэргүүлэгчид өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцэж, олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэж тогтоол гарган ажлын 3 хоногт багтааж ИТХ-ын дарга гарын үсэг зурж тамга даран баталгаажуулна.
- 3.14. Тэргүүлэгчдийн хурлыг хэлэлцэх асуудалтай уялдуулан зарим байгууллага, баг болон тодорхой заасан газарт зохион байгуулж болно.
- 3.15 Тэргүүлэгч хуралдаанд өөрөө оролцоогүй тохиолдолд материалыг дараа авч үзэн гаргасан шийдвэртэй танилцана.
- 3.16 Хурлын тэмдэглэлийг 1 хувь үйлдэж, хурлын дарга хянаж, гарын үсэг зурж баталгаажуулна. Хуралдааны тэмдэглэлд дараах зүйлийг заавал тусгасан байна.
- 3.16.1 хуралдаан эхэлсэн, засварласан, дууссан хугацаа /огноо, цаг минутаар/

3.16.2. хуралдаанд хэлэлцэж байгаа асуудалтай бүртэй холбогдож гарсан асуулт, хариулт, санал шүүмжлэл хэлсэн үг

3.16.3. Санал хураалтууд, гарсан шийдвэрийн төслийг олонхийн саналаар баталсан дүн, шийдвэрийн төслийг батлахад зөвшөөрсөн, татгалзсан тэргүүлэгчдийн нэрс

3.16.4. тэргүүлэгчдийн ирц, хуралдаанд хоцорч ирсэн, хуралдаан дундуур чөлөө авч буюу зөвшөөрөлгүй гарч явсан тэргүүлэгчдийн нэр, оролцоогүй цаг минут

3.17. Хуралдааны баримт бичигт дараах баримт бичгийг хавсаргана.

3.17.1. Тухайн хуралдаанаар хэлэлцсэн асуудлын жагсаалт

3.17.2.Хуралдаанд оролцоогүй тэргүүлэгчдийн нэр, шалтгаан, оролцсон бусад хүмүүсийн нэрс

3.17.3. Хуралдаанаас гаргасан шийдвэрийн нэг хувьд хуралдаанд анх оруулсан шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, дүгнэлт, санал, холбогдох бусад баримт бичиг, тооцоо судалгааг хавсарган хэлэлцсэн дарааллаар хадгална.

3.18. ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, ёсчлон гарын үсэг зурсан шийдвэрийн эх хувийг зохих журмын дагуу архивт шилжүүлнэ.